



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/171

Чингис хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Барилга, хот байгуулалтын сайдын "Эрх шилжүүлэх тухай" 2020 оны 24 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Барилга, хот байгуулалтын сайдаас аймгийн Засаг даргад хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн төсөл, арга хэмжээнээс сумдад эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмын дагуу шуурхай зохион байгуулж, гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/, барилга угсралт, их засварын ажлын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Баярхүү/ нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

03... Аймгийн Засаг даргын 2020 оны
 дугаар сарын 16 өдрийн 01/17
 дугаар захирамжийн хавсралт

Хуулийн дугаар	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	2020 онд санхүүжих	Эрх шилжүүлсэн ТЭЗ
		Эхлэх	Дуусах			
XI.1.88	Сумын төвийн гадна цэвэр усны шугам /Хэнтий, Батноров сум/	2020	2020	233.9	233.9	Батноров сумын Засаг дарга
XI.1.89	Сумын төвийн гадна цэвэр усны шугам /Хэнтий, Баянхутаг сум/	2020	2020	133.5	133.5	Баянхутаг сумын Засаг дарга
XI.1.90	Сумын төвийн гадна цэвэр усны шугам /Хэнтий, Мөрөн сум/	2020	2020	146.0	146.0	Мөрөн сумын Засаг дарга
XI.1.91	Сумын төвийн гадна цэвэр усны шугам /Хэнтий, Норовлин сум/	2020	2020	163.2	163.2	Норовлин сумын Засаг дарга
XI.1.92	Сумын төвийн гадна цэвэр усны шугам сүлжээ /Хэнтий, Жаргалтхаан сум/	2020	2020	242.0	242.0	Жаргалтхаан сумын Засаг дарга
	Нийт дүн			918.6	918.6	